MERIT
A CESO AND WUSC PROGRAM

IPAC IAPC

Төрийн албан дахь өөрчлөлт шинэчлэлийн сэтгэлгээ

2019 оны 10 дугаар сар

Монгол Улс, Улаанбаатар хот

Төрийн албаны инноваци

Инновацийг тодорхойлох нь

- Инноваци бол **ямар нэгэн ялгаатай зүйл бүтээх, аливааг өөрөөр хийх эсвэл аль алиныг нь хослуулах** үйл явц
- ЭЗХХАБ-ын тодорхойлсноор төрийн албаны инновацид дараах 3 шинж чанарыг агуулдаг:
  - **Шинэлэг байдал**: Инноваци нь ямар нэг шинэ элемент агуулах
  - **Хэрэгжихүйц**: Энэ нь зөвхөн онолын бус практикт хэрэгжих боломжтой
  - **Үр нөлөөтэй**: Илүү сайн үр дүн бий болгоход чиглэсэн




富嶽三十六景
神奈川沖
浪裏

Инноваци нь давалгаа адил тасралтгүй

- Олон хүн инновацийг өөрчлөлт шинэчлэлийн томоохон давалгаа байх болно гэж боддог ч үнэн хэрэгтээ тийм биш юм.
- Ихэнхдээ инноваци “томоохон давалгаа” байдлаар хийгддэггүй.
- Харилцан хамааралтай хэд хэдэн үйл ажиллагаа нь инновацлаг сэтгэлгээг өдөөх замаар инновацийн соёлыг төлөвшүүлж инновацийн үйл ажиллагаа (бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажил хэрэг, үйл явц зэрэг)-г бий болгодог.




Инновацийн аргачлал

- Инновацийг байгууллагын бий болгож буй багц бүтээгдэхүүн гэхээс илүүтэй **тухайн ажлыг хийж, гүйцэтгэх аргачлал** гэж ойлгох нь зүйтэй.
- Үүнд:
  - Манлайллын арга барил
  - Байгууллагын гадна, дотноос суралцах чадвар
  - Ажиллагсдын сэтгэлгээ, хандлага
  - Байгууллагын чадавх зэрэг багтана.



Инновацилаг байдал

Сэтгэлгээ



Инноваци

Аргачлал



Инновацийн бүтээгдэхүүн

Үр дүн

Инновацийн соёлын гол шинжүүд

- Инновацийг хурдасгахад дараах инновацийн соёлын шинж чанарыг харгалзах:
  - **Харилцан итгэлцэл өндөр түвшинд байх;**
  - **Олон талт оролцоог хангах;**
  - **Эрсдэлээс айхгүй байх, алдаа эндэгдлийг ойлгож хүлээн авах.**

Инновацийн арга зам

Байгууллагын орчинд	Энэхүү загварын үндсэн ойлголт нь “зөв” бүтэцтэй, “зөв” соёлтой инновацийн бүтээл бий болгох дээд зэргийн чадамжтай төрийн алба юм.
Инноваци нь халдвартай адил	Инновацийг ашигтай вирустай адилтган үздэг ба байгууллага нь өөрчлөлтийг тэсвэртэй, уян хатнаар даван туулна.
Интрапренершип **(Байгууллага, компанийн дотор үйл ажиллагаа эрхлэх)**	Төрийн байгууллагад олон жил ажилласан боловч ур чадвар, харилцаа холбоогоо бүрэн ашиглахгүй байгаа инноватор албан хаагчдынхаа нөөцөд тулгуурлана.
Дасан зохицох систем	Эдгээр загвар нь төрийн албаны шийдвэр гаргалтад оролцогчдын тоог нэмэгдүүлэх шинэ үзэл баримтлалын хөгжилд тулгуурладаг.

Инновацийг хэрэгжүүлэх нь



Өөрчлөлтийн соёл

Дасан зохицох засаглал

- **Амжилт гаргах магадлалыг нэмэгдүүлэхийн тулд бид:**
  - Байгууллагууд тус тусын эрхлэх асуудлын хүрээнд **зөрчлийг шийдвэрлэж**, **ажлын уялдаа холбоог нь сайжруулах** зорилгоор засаглалын ерөнхий зарчмыг баримтлан **инновацийг дэмжих** нь зүйтэй.
  - Инновацид үзүүлэх хамтын ажиллагааны үр нөлөөг дутуу үнэлж болохгүй.

Орчин, оролцогч талууд

- **Орчин нөхцөлөө ойлгох:**
  - **хэд хэдэн үр дүнд хүрэх арга замыг олох нь нэн чухал** гэдгийг ойлгох
  - **системийн онолоос суралцах үнэ цэнийг ухамсарлах** (аль байгууллага, агентлагаас суралцахыг хүсч байна вэ?)
  - **оролцогч талуудыг боловсруулах шатанд оролцохыг нь дэмжих** (тэдний санаа оноо зөв боловсруулалт хийхэд нэн чухал)



Шинийг санаачлагчийн зөвлөмж:

Та систем тогтолцооны онцлогийг ойлгосноор оролцогч талын хэрэгцээ шаардлагад нийцсэн шийдлийг олж чадна.

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

IPAC IAPC

Баг хамт олондоо дэмжлэг үзүүлэх

- **Хамт олноо хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх:**
  - Байгууллагын албан хаагчдын зүгээс эсэргүүцэл үзүүлэх нь өөрчлөлт, шинэчлэлт хийхэд ихээхэн саад болдог.
  - Байгууллага дотор үүссэн фракц нь хамт олны уур амьсгалыг эвддэг.
  - Хувирган өөрчлөх манлайлагч нь **өөрчлөлт шинэчлэлтийн хүрээнд хамт олны дунд харилцан хүндлэлийг бий болгож, тэднийг дэмжих, менторлох, туслах болон хөгжүүлэх** чадвартай байдаг.

    Нэгэнт тогтсон байдал-хэвшмэл сэтгэлгээг эвдэхэд хэзээ ч амархан байхгүй. Ийм учраас албан хаагчид ядаргаанд орж, итгэл найдвараа алдаж байгаа эсэхэд анхаарч, хамт олондоо туслахад бэлэн байх нь чухал.



Шинийг санаачлагчийн зөвлөмж:

Өөрчлөлт хийх санаачилгыг манлайлж буй хүний хувьд таны хамгийн чухал чанар бол баг хамт олноо дэмжих явдал юм.

Зөвшөөрүүлэн баталгаажуулах

- **Чин сэтгэлийн дэмжлэг авах:**
  - Өөрчлөлтөөс гарах үр нөлөөг эрх баригчдад бүрэн ойлгуулсны үр дүнд өөрчлөлтийг богино хугацаанд зөвшөөрүүлэх боломжтой.



Шинийг санаачлагчийн зөвлөмж:

Өөрчлөлт хийх санаачилгыг төрийн байгууллагын хэрэгцээ шаардлага, чиг үүрэгтэй уялдуулах

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

IPAC IAPC

Шантралгүй зүтгээрэй

- **Өөрчлөлтийг тасралтгүй өрнүүлэх нь чухал.**
  - Томоохон хэмжээний өөрчлөлт бэрхшээлгүй хийгдэж байсан нь үгүй.
    - *Дотоод эсэргүүцэл*
    - *Гадаад эсэргүүцэл*
  - Албан хаагчдын эсэргүүцлээс үүдэлтэй бухимдалд **үргэлж эерэгээр хандах** хэрэгтэй.
  - Эсэргүүцлийн нөлөөг бууруулахад **өөрчлөлтийг түүчээлэгчдийн дуу хоолойг** ашиглах.
  - **Нөлөө бүхий дэмжигчдийн баг** бүрдүүлж, хамтран ажиллах.



Шинийг санаачлагчийн зөвлөмж:

Өөрчлөлт хийх санаачилгын явцад болон дараа нь ч эсэргүүцэлтэй тулгарна гэдэгт бэлтгэлтэй байх. Дэмжигчдийн багаар дамжуулан сөрөг нөлөөллийг нь аль болох бууруулах.

MERIT A CESO AND WUSC PROGRAM | IPAC IAPC

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

IPAC IAPC

Баярлалаа!

Асуулт, хариулт